

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ  
“ГАН ХИЙЦ” ХК-НИЙ  
2023 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусвар тайлан

2024 он



## ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,  
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,  
E-mail: byambaahunnu@yahoo.com, <http://www.dumaudit.mn>

2024.03.06 № 55

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

##### Зөрчилгүй санал дүгнэлт

"Ган хийц" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

##### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Аудитаар "Ган хийц" ХК -ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

##### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий ЭТГЭЭДҮҮДИЙН Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### **Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитын ажлаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

### **Тайлангийн хэрэглээний хязгаарлалт**

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО

Огноо: 2023.03.04



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### **01. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Ган хийц ХК (цаашид "компани" гэх) нь 1985 онд барилгын төмөр хийц үйлдвэрлэл чиглэлээр анх үүсгэн байгуулагдсан байна. Регистр 2090988, Улсын бүртгэлийн гэрчилгээ 90100001016 дугаартай 2 гишүүнтэй 24,246.4 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй 140 гишүүнтэй. Гүйцэтгэх захирлаар 2022 оны 07 дугаар сараас Даваасүрэн овогтой Оюунзул ажиллаж байна. Гүйцэтгэх захирал Д.Оюунзулыг гүйцэтгэх захирлаар томилсон шийдвэрийн өөрчлөлтийн бүртгэлийг Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгаагүй байна.

Ган хийц ХК нь Монгол Улсын барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглан, холбогдох чанар стандартын шаардлага хангасан эцсийн бүтээгдэхүүнийг бэлтгэн, харилцагчиддаа газар дээр нь хурдан шуурхай хүргэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Ган хийц ХК нь жилд 300 тн төмөр хийц үйлдвэрлэх хүчин чадалтай, тоног төхөөрөмж бүхий төмөр хийцийн үйлдвэртэй. Ган хийц ХК-ний үйлдвэр, оффис нь Улаанбаатр хот, Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо, Нарангийн гудамж, Ган хийц ХК-ний өөрийн байранд байрладаг.

### **КЭБАТ-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

№	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Д.Оюунзул	Гүйцэтгэх захирал	0 %
2	Х.Ариунсанаа	Нягтлан бодогч	0 %

### **ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ**

№	Овог Нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	М.Даваасүрэн	ТУЗ-ийн дарга	71 %
2	Ж.Долгорсүрэн	ТУЗ-ийн гишүүн	0 %
3	Б.Гантулга	ТУЗ-ийн гишүүн	0 %
4	Б.Ганбат	ТУЗ-ийн гишүүн	0 %
5	Б.Эрдэнэбаяр	ТУЗ-ийн гишүүн	0 %
6	П.Төвсанаа	Хараат бус ТУЗ-ийн гишүүн	0 %
7	Ц.Хангай	Хараат бус ТУЗ-ийн гишүүн	0 %
8	Э.Ууганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	0 %
9	Д.Оюунзул	ТУЗ-ийн гишүүн	0 %

### **НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД**

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	Маньдар Даваасүрэн	71 %	Байхгүй	Байхгүй
2	Хасвуу ХХК	18 %	Байхгүй	Байхгүй
3	Аргай бэст ХХК	1 %	Байхгүй	Байхгүй
4	Бусад	10 %	Байхгүй	Байхгүй



Ган хийц ХК -ний 242,464 ширхэг хувьцаанд үнэт цаасны 30 компанид 140 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна.

Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд гүйцэтгэх удирдлага томилсон тушаалын болон компанийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн шинэчлэл хийгээгүй байна.

.Тус компанийн 2023 оны санхүүгийн үзүүлэлтийг товч харуулбал:

#### **САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

- Нийт хөрөнгө-**5,232,818,386.1**
- Өр төлбөрийн нийт дүн-**4,505,105,555.52**
- Эзэмшигчдийн өмчийн дүн-727,712,830.58
- Нийт гаргасан хувьцаа-**242,464ш**

#### **ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**

- Нийт борлуулалтын орлого-**8,273,251,449.09**
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг-**7,266,919,149.82**
- Нийт ашиг/ алдагдал-(**126,568,341.88**)
- Цэвэр ашиг/алдагдал-(**136,831,366.05**)
- Ногдол ашиг /энгийн/**0**
- Ногдол ашиг /давуу эрхийн/**0**
- Нэгж хувьцааны дансны үнэ-**100**

#### **САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД**

- Нийт хөрөнгийн өгөөж /ROA/- (-0.03)
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/-(-5.64)
- Нийт хөрөнгийн эргэц /ROTA/-(0.63)
- Нэгж хувьцааны өгөөж /EPS/- (-564.33)

Тус компани алдагдалтай ажилласнаас шалтгаалан санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд хангалтгүй сөрөг гарсан нь эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байна.

#### **САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ**

Тус компани нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалын Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 1 дүгээр, "Санхүүгийн тайлангийн А маягт"-ыг 2 дугаар хавсралтуудыг үндэслэн бэлтгэсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

#### **Стандартын баримтлал ба хэрэгжүүлэлт**

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол Улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

## **02. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОХ БОДЛОГУУД**

### **Гадаад валютын хөрвүүлэлт**

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг.

### **Холбоотой талууд**

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талууд оршин байдаг ба түүнтэй холбоотой санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцдог хувьцаа эзэмшигчийн төлбөр тооцооны асуудлыг тодруулан тайлагнасан байна.

### Зээлийн хүү

Зээлийн хүүг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаа бүрд анх бүртгэсэн нэрлэсэн үнэ болон зээлийн хүүг төлсөн үеийн үнийн зөрүүгээр хорогдуулж зээлийн хугацаанд үүссэн олз, гарзыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүүгийн аргыг ашиглан орлого үр дүнгийн тайланд ашиг, алдагдлаар тусгана.

### Санхүүгийн тайлан тодруулга, НББ-ын программ хангамжийн талаар.

Компани нь нягтлан бодох бүртгэлийг "Diamond" программ ашиглан бүртгэдэг.

#### 1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах данснуудаас бүрддэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэсэн байна.

#### Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Касс дахь мөнгө	229,227,280.23	24,633.60
2	Банкин дахь мөнгө	106,752,053.64	30,977,739.24
3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	0.0	0.0
4	<b>Нийт дүн</b>	<b>335,979,333.87</b>	<b>31,002,372.84</b>

Компани нь жижиг мөнгөн сан ашиглан мөнгөн гүйлгээг бэлнээр хийж, хадгалж буй нь эрсдэлийг дагуулж байна.

Бэлэн мөнгөний тооллогын бүртгэл нотломж, үлдэгдлийн баталгаажилт хийгээгүй байдлыг дахин хянуулах.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн доорх заалтуудыг зөрчсөн. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна; 13.6-д Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна; 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд мөрдөн ажиллах.

#### Дансны авлага

/ төгрөг/

№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулаг	Дансны авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл	2,096,123,749.86	0.0	2,096,123,749.86
2	Нэмэгдсэн	2,099,022,403.47	0.0	2,099,022,403.47

3	Хасагдсан		0.0	
3.1	-Төлөгдсөн	2,367,438,705.60	0.0	2,367,438,705.60
3.2	-Найдваргүй болсон		0.0	
4	Эцсийн үлдэгдэл	1,827,707,447.73	0.0	1,827,707,447.73

Авлага нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн нөөцийн сан байгуулдаггүй. Иймд авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн нөөцийн сан байгуулж байх

#### Татварын авлага

/ төгрөг/			
№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	НӨАТ-ын авлага	37,804,894.14	67,283,625
2	НДШ-ийн авлага		
	Нийт дүн	37,804,894.14	67,283,625

Татварын авлага дансанд НӨАТ төлөгч харилцагчаас зээлээр худалдан авсан худалдан авсан бараа, ажил үйлчилгээний НӨАТ-ыг хойшлогдсон НӨАТ-ын авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

#### Бусад богино хугацаат авлага

/ төгрөг/			
№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн	0.0	0.0
2	Ажиллагдаас авах авлага	0.0	0.0
3	Ноогдол ашгийн авлага	0.0	0.0
4	Хүүний авлага	0.0	0.0
4	Богино хугацаат авлагын бичиг	0.0	0.0
4	Бусад талуудаас авах авлага	9,628,241.38	600,284,509.81
4	Хүмүүсээс авах авлага	0.0	0.0
4	Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага	0.0	0.0
4		0.0	0.0
4	Нийт дүн	9,628,241.38	600,284,509.81

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж авлагын дансны үлдэгдлийг баталгаажуулан тооцоо нийлсэн актууд үйлдсэн байна.

#### Бараа материал

Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ буюу цэвэр боломжит өртгөөр нь бүртгэдэг. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад тооцсон зардлыг хассан дүн юм.

/ төгрөг/

№	Үзүүлэлт	Түүхий эд материал	ББ	Хангамжийн материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Нийт дүн
1	<b>Эхний үлдэгдэл (өртгөөр)</b>	45,993,188.26	11,802,880.37	1,143,904,753.45	3,130,543,893.62	4,332,244,715.7
2	Нэмэгдсэн дүн	119,706,879.6	0.0	1,005,938,958.87	4,456,539,702.77	5,582,185,541.24
3	Хасагдсан дүн	104,640,908.48	14,784	1,750,719,601.97	7,587,056,323.67	9,442,431,618.12
4	<b>Эцсийн үлдэгдэл (өртгөөр)</b>	61,060,181.83	11,788,096.37	399,123,087.90	27,272.72	471,998,638.82
5	Үнийн бууралтын гарз (-)					
6	Үнийн бууралтын буцаалт					
7	Дансны цэвэр дүн	61,060,181.83	11,788,096.37	399,123,087.90	27,272.72	471,998,638.82
7.1	Эхний үлдэгдэл	45,993,188.26	11,802,880.37	1,143,904,753.45	3,130,543,893.62	4,332,244,715.7
7.2	Эцсийн үлдэгдэл	61,060,181.83	11,788,096.37	399,123,087.90	27,272.72	471,998,638.82

Бараа материалын байнгын систем ашигладаг ба дундаж өртгийн аргыг хэрэглэдэг. Бараа материалын хувьд худалдан авалтын оффисын хангамжийн тооцоог бараа материалын дансаар дамжуулаагүй, тооцооны дансаар дамжуулан, шууд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

#### Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
	<b>Нийт дүн</b>	0.0	0.0

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө байхгүй.

#### Урьдчилж төлсөн зардал, тооцоо

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Урьдчилж төлсөн зардал	239,898,103.8	220,024,288.05
2			
4	<b>Нийт дүн</b>	<b>239,898,103.8</b>	<b>220,024,288.05</b>

Урьдчилж төлсөн зардлын эхний үлдэгдлийн дүнгээс 19,873,815.75 төгрөгийг тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрсөн.

#### Үндсэн хөрөнгө



Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цээнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцож, байгуулдаг бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг татварын аргаар тооцдог, жилийн эцсийн тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулсан байна. ТУЗ-ын шийдвэрээр 203,513,814.84 төгрөгийн анхны өртөгтэй, 144,154,974.58 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 25 ширхэг хөрөнгийг актлан данснаас хасч 59,358,840.26 төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан гарз хүлээн зөвшөөрсөн байна.

Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин, тоног	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Нийт дүн
<b>Эхний үлдэгдэл</b>	1,810,540,973.17	361,581,507.35	655,474,918.40	33,155,438.55	4,897,636.36	2,865,650,473.83
Нэмэгдсэн дүн				1,047,272.73	6,400,000.00	7,447,272.73
Өөрөө үйлдвэрлэсэн						
Хасагдсан дүн						
Худалдсан (-)			109,884,914.78			109,884,914.78
Бусад	24,304,000.00	46,823,940.58	128,699,698.17	3,686,176.09		203,513,814.84
<b>Эцсийн үлдэгдэл</b>	1,786,236,973.17	314,757,566.77	416,890,305.45	30,516,535.19	11,297,636.36	2,559,699,016.94
<b>ХУРИМТЛАГД САН ЭЛЭГДЭЛ</b>						
Эхний үлдэгдэл	447,978,166.44	90,454,813.16	389,031,451.78	13,063,618.28	1,962,399.01	942,490,448.67
Нэмэгдсэн дүн	81,598,847.87	29,251,947.59	29,948,707.77	3,350,921.21	2,571,149.60	146,721,574.04
Байгуулсан элэгдэл	81,598,847.87	29,251,947.59	29,948,707.77	3,350,921.21	2,571,149.60	146,721,574.04
Хасагдсан дүн	6,682,573.72	34,664,752.02	173,990,810.11	3,545,649.05		218,883,784.90
Данснаас хассан хөрөнгийн нэлэгдэл	6,682,573.72	34,664,752.02	173,990,810.11	3,545,649.05		218,883,784.90
Эцсийн үлдэгдэл	522,894,440.59	85,042,008.73	244,989,349.44	12,868,890.44	4,533,548.61	870,328,237.81
<b>ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН</b>						
Эхний үлдэгдэл	1,362,562,806.73	271,126,694.19	266,443,466.62	20,091,820.27	2,935,237.35	1,923,160,025.16
Эцсийн үлдэгдэл	1,263,342,532.58	229,715,558.04	171,900,956.01	17,647,644.75	6,764,087.75	1,689,370,779.13

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2. эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; 12.2.3. эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед; 12.2.5. аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дампуурлын хэрэг үүсгэсэн үед; 12.2.6. хуульд заасан бусад тохиолдолд;



гэсэн заалтуудыг хэрэгжүүлж үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийж тооллогын комиссын дүгнэлт үйлдсэн байна.

### Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд 2,241,926.85 мянган төгрөгийн программ хангамж бүртгэсэн байна.

/ төгрөг/			
№	Үзүүлэлт	Программ хангамж	Нийт дүн
1.1	Эхний үлдэгдэл	2,241,926.85	2,241,926.85
1.2	Нэмэгдсэн дүн	0.0	0.0
1.2.1	Өөрөө үйлдвэрлэсэн	0.0	0.0
1.3	Хасагдсан дүн	0.0	0.0
1.3.1	Худалдсан	0.0	0.0
1.4	Эцсийн үлдэгдэл	0.0	0.0
2	<b>ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ</b>	0.0	0.0
2.1	Эхний үлдэгдэл	0.0	0.0
2.2	Нэмэгдсэн дүн	0.0	0.0
2.2.1	Байгуулсан хорогдол	227,814.75	227,814.75
2.3	Хасагдсан	0.0	0.0
2.3.1	Данснаас хассан хөрөнгийн хорогдол	0.0	0.0
2.4	Эцсийн үлдэгдэл	2,014,112.10	2,014,112.10
3	<b>ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН</b>	2,014,112.10	2,014,112.10
3.1	Эхний үлдэгдэл	2,241,926.85	2,241,926.85
3.2	Эцсийн үлдэгдэл	2,014,112.10	2,014,112.10

### Бусад эргэлтийн бус хөрөнгө

/ төгрөг/			
№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.0	0.0
	<b>Нийт дүн</b>	0.0	0.0

Бусад эргэлтийн бус хөрөнгө байхгүй.

### Дансны өглөг

Богино хугацаат өр төлбөр нь тайлант хугацаанд үүссэн бараа, үйлчилгээний худалдан авалт, үйл ажиллагааны зардал, татвар, шимтгэл, цалинтай холбогдох өглөг бөгөөд тэдгээрийг үүссэн тухайн үеийн нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг. Өглөгийн хувьд хөнгөлөлт, хасагдуулаг

тооцдоггүй. Дансны өглөгийн эхний, эцсийн үлдэгдэл баталгаажсан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хангаж ажилласан байна.

### Дансны өглөг

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Урьдчилж олсон орлого	4,244,390,848.09	0.0
2	Цалингийн өглөг	391,003.40	4,308,658.05
3	Ногдол ашгийн өглөг	96,094,391.46	81,189,958.99
4	Зээлийн хүүгийн өглөг	0	48,811,353.00
5	Дансны өглөг	2,437,814,198.71	2,302,778,701.46
	<b>Нийт дүн</b>	<b>6,778,690,441.66</b>	<b>2,437,088,671.50</b>

Өмнө онуудад хүлээн авсан барилгын гэрээний орлогыг хойшлуулж урьдчилж олсон орлогоор бүртгэснийг тайлант онд борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

### Татварын өр

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	ААНОАТ өр	87,466,999.42	75,533,502.1
2	НӨАТ -ын өр	139,475,671.58	790,635,244.55
3	ХХОАТ -ын өр	11,056,689.97	64,168,636.49
4	НДШ-ийн өглөг	11,955,073.9	84,147,575.92
5	Бусад татварын өр	1,086,183.75	115,918,671.64
	<b>Нийт дүн-</b>	<b>251,040,618.62</b>	<b>1,130,403,630.7</b>

Татварын тооцооллыг цахим татварын систем дэх өглөгийн үлдэгдэлтэй тулган шалгахад тохирч байна. Тодруулга тайланд Цалин өглөг-/391,003.4₮: 4,308,658.05₮,/ НДШ өглөг /11,955,073.9₮ 84,147,575.92₮,-ийн эхний, эцсийн үлдэгдлүүд тусган тайлагнаж баталгаажуулсан боловч төсөвт төлөх үүргээ биелүүлээгүй ажилласан байна. Иймд төсөвт төлөх үүргээ биелүүлж ажиллах.

### Богино хугацаат зээл

/ төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	валютаар	2023.12.31	валютаар
1	Төлөгдөх хугацаандаа байгаа	1,374,999,600	0.0	774,835,649.32	0.0
2	Хугацаа хэтэрсэн	0.0	0.0	0.0	0.0
3		0.0	0.0	0.0	0.0
	<b>Нийт дүн</b>	<b>1,374,999,600</b>	<b>0.0</b>	<b>774,835,649.32</b>	<b>0.0</b>

Тайлант онд 100,0 сая төгрөгийн богино хугацаат зээл авч, өмнөх зээлийн үлдэгдлээс 700,1 сая төгрөгийн зээлийг төлсөн байна. Нийт 3-н зээлийн үлдэгдлийг ХААН банкны зээлийн харилцах дансны хуулгаар тулган шалгахад тохирч байна.

### Бусад богино хугацаат өр төлбөр

Бусад богино хугацаат өр төлбөрт туслан гүйцэтгэгч нарт төлөх төлбөрийн үлдэгдэл буюу барилгын хуулийн шаардлагаар баталгаат хугацааны өглөгийг тусгасан байна. 17 харилцагчийн 162,777,604 төгрөгийн баталгааны өглөг байна.

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	162,777,604
	0.0	0.0
<b>Нийт дүн</b>	<b>0.00</b>	<b>162,777,604</b>

### Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бөгөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасаж тооцдог. Компанийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт дараах байдалтай байна. Үүнд:

- Төсөлт ажлын борлуулалтын орлого /Ажил үйлчилгээ үзүүлсний орлого/
- Үйлдвэрлэх цехийн борлуулалтын орлого
- Барилгын зургийн борлуулалтын орлого
- Түрээсийн орлого
- Бусад борлуулалтын орлого

Орлогоос нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан дүнгээс худалдааны хөнгөлөлт, буцаалт зэргийг хасаж тооцдог боловч тайлант онд борлуулалтын буцаалт хийгдээгүй байна. Тайлант онд өмнөх онуудад хүлээн авсан урьдчилж олсон орлого 4,244,390,848.09-ийг тухайн ажил дууссантай холбогдуулан тайлант оны борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрсөн байна. Тайлант оны 1-12-р сарын НӨАТ-ын тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын өссөн дүнг орлогын албан татварын тайлангаарх тайлагнасан дүн, санхүүгийн тайлангаар тайлагнасан орлогын дүнтэй тулган шалгахад зөрүүгүй буюу тохирч байсан.

### Борлуулалтын орлого болон борлуулалтын өртөг

/төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого:	7,467,792,678.75	8,273,251,449.09
1.1	Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого:	7,467,792,678.75	8,273,251,449.09
3	Нийт борлуулалтын орлого		
4	<b>Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт (-)</b>		
5	<b>Цэвэр борлуулалт</b>	<b>7,467,792,678.75</b>	<b>8,273,251,449.09</b>
	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг:</b>		

6.1	Борлуулсан бараа, борлуулалтын өртөг	6,140,741,500.00	7,266,919,149.82
8	<b>Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>	<b>6,140,741,500.00</b>	<b>7,266,919,149.82</b>

Борлуулалтын орлогыг НӨАТ-ийн тайланд тайлагнасан, жилийн өссөн дүнгээр ААНОАТ-д бүрэн тусгасан байна.

#### Хүүгийн орлого

Үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч аккурэл сууриар бүртгэдэг.

#### Бусад орлого

Үзүүлэлт	/ төгрөг/	
	2022.12.31	2023.12.31
Бусад орлого	127,306,500.00	0.0
<b>Дүн</b>	<b>127,306,500.00</b>	<b>0.0</b>

#### Бусад зардал

№	Үзүүлэлт	/ төгрөг/	
		2022.12.31	2023.12.31
1	Үйл ажиллагааны бус зардал	171,608,151.29	0
2	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	0	59,358,840.26
	<b>Нийт дүн</b>	<b>171,608,151.29</b>	<b>59,358,840.26</b>

#### Ерөнхий удирдлагын зардал

№	Үзүүлэлт	/ төгрөг/	
		2022.12.31	2023.12.31
1	Ажиллагчдын цалингийн зардал	328,483,200	379,845,306.72 ✓
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	50,575,700	51,427,874.15 ✓
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	50,575,700	30,877,826.00 ✓
4	Томилолтын зардал	3,615,600	20,903,550.41 ✓
5	Бичиг хэргийн зардал	5,262,800	3,806,983.05 ✓
6	Шуудан холбооны зардал	7,279,800	17,343,231.69 ✓
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал	17,685,800	
8	Сургалтын зардал	10,862,700	4,750,000.00 ✓

9	Сонин сэтгүүл захиалгын зардал	0.0	0.0
10	Даатгалын зардал	1,047,100	5,624,020.00
11	Ашиглалтын зардал	38,054,800	54,073,676.19
12	Засварын зардал	51,721,500	29,736,402.57
13	Элэгдэл, хорогдлын зардал	51,469,900	107,642,445.10
14	Түрээсийн зардал	30,175,200	0.0
15	Харуул хамгааллын зардал	21,657,300	14,956,468.78
16	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	3,179,400	1,841,740.34
17	Тээврийн зардал	1,525,000	1,955,454.55
18	Шатахууны зардал	24,643,000	19,529,783.64
19	Зээлийн хүүгийн зардал	0.0	173,404,014.77
20	Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	0.0	11,863,006.06
21	Хангамжийн материал	28,420,900	0.0
21	бусад зардал	29,815,100	72,370,276.58
	<b>Нийт дүн</b>	<b>760,178,400</b>	<b>1,001,952,060.60</b>

#### Эздийн өмч

##### Өмч

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	/ төгрөг/			
			Дүн (төгрөгөөр)	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	(Төгрөгөөр)
1	Эхний үлдэгдэл	242,464	24,246,400.00	242,464	24,246,400.00	
2	Нэмэгдсэн	0	0	0	0	
3	Хасагдсан	0	0	0	0	
4	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>242,464</b>	<b>24,246,400.00</b>	<b>242,464</b>	<b>24,246,400.00</b>	

Тус компанийн эзэмшигчдийн өмч нь өөрийн хөрөнгө (дүрмийн сан), эздийн өмч, өмнөх үеийн болон тайлант хугацааны хуримтлагдсан ашиг, алдагдлаас бүрддэг. Компани нь 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар нийт хөрөнгөөс өр төлбөрийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн / 5,232,818,386.10 - 4,505,105,555.52 / = 727,712,830.58 төгрөг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн / 24,246,400.00 төгрөг / -гээс 703,466,430.58 төгрөгөөр хөрөнгийн чадвар өссөн байна. Тайлант онд өмнөх үеийн хуримтлагдсан ашгаас 17,786,700.00 төгрөгийн ногдол ашиг тараасан байна.

#### Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг хэрэгжүүлэх ажлын талаар:

1. Өмнөх оны аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
2. Компани нь тайлант үед алдагдалтай ажилласныг анхаарч өөрийн хөрөнгийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх; ашигтай ажиллах
3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг хуулийн хугацаанд төлж байх, төсөвт төлөх үүргээ биелүүлж ажиллах;
4. Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг хийх;



## ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Төмөрчний гудамж, Их найман шарга 10 давхар,  
Утас: 9908-5151, 9199-1462, Факс: (976-11) 32-52-62,  
E-mail: byambaahunnu@yahoo.com, http://www.dumaudit.mn

2024.03.06 № 55  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

“ГАН ХИЙЦ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.ОЮУНЗУЛ,  
ТУЗ-ЫН ДАРГА М.ДАВААСҮРЭН  
БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ  
НАРТ

### УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ

#### 1. Санхүүгийн тайлагналын талаар

Бодит байдал:

1. Кассын үлдэгдэл тоолсон актгүй, Харилцахын хуулга, дансны үлдэгдлийг баталгаажуулаагүй
2. Бараа материалын зарим худалдан авалтын И баримтыг хавсаргаагүй.
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөөгүй.
4. Бараа материалын бүртгэл эмх цэгцгүй, Бараа материалын хэт олон данс /21 данс/ ашигладаг.

Дээрх зөрчлийг арилган, санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулж ажиллахыг удирдлагын сонорт анхааруулж байна.

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, мөрдөж ажиллах
2. Тайлант үед касс, банкны харилцах дансны үлдэгдлийг баталгаажуулж байх.
3. НББ-ийн анхан шатны баримт, бүртгэл тайланг И баримтаар баталгаажуулж ажиллах
4. Бараа материалын дансны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах
- 5.

#### 2. Дотоод хяналтын талаар

Бодит байдал:

1. Санхүүгийн тайланд тусгасан татварын өглөг 2023 оны 12 дугаар сарын 31- өдрийн байдлаар 1,046,256,054.78 буюу өмнөх оны үлдэгдлээс 879,363,012 төгрөгөөр нэмэгдсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 84,147,575.92 буюу өмнөх оны үлдэгдлээс 72,192,502.02 төгрөгөөр нэмэгдсэн байна. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг хуульд заасан хугацаанд төлөөгүй, төсөвт төлөх үүргээ биелээгүй байна.
2. Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг өөрчлөлт орсон тухай бүр хийгээгүй;
3. Тайлант онд ХААН банкны тусгай нөхцөлт зээлийн хугацаа дууссан боловч зээлийг төлж барагдуулаагүй.

Зөвлөмж:

1. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг хуульд заасан хугацаанд төлж, төсөвт төлөх үүргээ биелүүлж ажиллах;
2. Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг өөрчлөлт орсон тухай бүр хийх;
3. Богино болон урт хугацаат зээлийн тооцоо, төлбөрийг тайлант хугацаанд нь барагдуулах, холбоотой талын тооцоог тодруулж, эрсдэлээс сэргийлэн хяналт тавьж ажиллах;

#### 3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар

Компанийн удирдлага, нягтлан бодогч нар нь дараах эрх, үүргийг баримталж ажиллах Үүнд:



5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ; гэсэн заалтыг хэрэгжүүлж кассын дансны үлдэгдлийг сар бүр тоолж, үлдэгдлийг баталгаажуулж хэвших;
6. Богино болон урт хугацаат зээлийн тооцооны төлбөрийг хугацаанд нь барагдуулах, холбоотой талын тооцоог тодруулж, эрсдэлээс сэргийлэн хяналт тавьж ажиллах;
7. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;
8. Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах зэргийг зөвлөж байна.

Дундманхайдай аудит ХХК:  
Захирал  
Аудитор



Ж.Бямбажав  
Ц.Цэрэнхүү

Ган хийц ХК:

Зөвшөөрч  
Танилцсан: Захирал

Нягтлан бодогч

Д.Оюунзул  
Х.Ариунсанаа

A handwritten signature in black ink, consisting of several loops and a long horizontal stroke.





**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**

**АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2022.12.31	2023.12.31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	335,979,333.87	31,002,372.84
1.1.2	Дансны авлага	2,096,123,749.86	1,827,707,447.73
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	37,804,894.14	67,283,625.00
1.1.4	Бусад авлага	9,628,241.38	600,284,509.81
1.1.6	Бараа материал	4,332,244,715.70	471,998,638.82
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	239,898,103.80	220,024,288.05
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>7,051,679,038.75</b>	<b>3,218,300,882.25</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,923,160,025.16	1,689,370,779.13
1.2.2	Биет бус хөрөнгө	2,241,926.85	2,014,112.10
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	323,132,612.62	323,132,612.62
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,248,534,564.63</b>	<b>2,014,517,503.85</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,300,213,603.38</b>	<b>5,232,818,386.10</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,437,814,198.71	2,302,735,989.42
2.1.1.2	Цалингийн өглөг	391,003.40	4,308,658.05
2.1.1.3	Татварын өр	252,237,591.19	1,046,256,054.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг	11,955,073.90	84,147,575.92
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,374,999,600.00	774,835,649.32
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	48,811,353.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	96,094,391.46	81,189,958.99
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	4,244,390,848.09	0.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	42,712.04
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	162,777,604.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,417,882,706.75</b>	<b>4,505,105,555.52</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,417,882,706.75</b>	<b>4,505,105,555.52</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	24,246,400.00	24,246,400.00



2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	798,700,593.97	798,700,593.97
2.3.9	Хуримтлагдсан ашиг	59,383,902.66	-95,234,163.39
2.3.11	Эздийн өмчийн дүн	882,330,896.63	727,712,830.58
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>9,300,213,603.38</b>	<b>5,232,818,386.10</b>

### АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>7,467,792,678.75</b>	<b>8,273,251,449.09</b>
2	Борлуулалтын өртөг	6,140,741,539.18	7,266,919,149.82
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>1,327,051,139.57</b>	<b>1,006,332,299.27</b>
4	Түрээсийн орлого	271,291,090.00	54,300,366.25
5	Хүүгийн орлого	0.00	23,761.89
6	Ерөнхий ба удирдлагын зардал	760,178,365.02	828,548,045.83
7	Санхүүгийн зардал	105,680,476.95	173,404,014.77
8	Бусад зардал	24,028,326.00	0.00
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )	8,148,898.86	427,120.35
10	<b>Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )</b>	<b>0.00</b>	<b>-59,358,840.26</b>
11	<b>Бусад ашиг ( алдагдал )</b>	<b>-20,273,351.29</b>	<b>-126,340,988.78</b>
12	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>696,330,609.17</b>	<b>-126,568,341.88</b>
13	Орлогын татварын зардал	72,126,257.99	10,263,024.17
14	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>624,204,351.18</b>	<b>-136,831,366.05</b>
15	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
16	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>624,204,351.18</b>	<b>-136,831,366.05</b>
17	<b>Орлогын нийт дүн</b>	<b>624,204,351.18</b>	<b>-136,831,366.05</b>



АУДИТ ХИЙСЭН ӨМЧ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400.00	798,700,593.97	-564,511,539.43	258,435,454.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	24,246,400.00	798,700,593.97	-564,511,539.43	258,435,454.54
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	624,204,351.18	624,204,351.18
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400.00	798,700,593.97	59,383,902.66	882,330,896.63
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	24,246,400.00	798,700,593.97	59,383,902.66	882,330,896.63
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	17,786,700.00	17,786,700.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )	0.00	0.00	-136,831,366.05	-136,831,366.05
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
17	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400.00	798,700,593.97	-95,234,163.39	727,712,830.58



## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,024,657,503.57	4,024,657,503.57
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	4,024,657,503.57	4,024,657,503.57
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,170,298,297.91	4,170,298,297.91
1.2.1	Ажиллагчдад төлсөн	326,637,928.90	326,637,928.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	83,688,951.59	83,688,951.59
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,590,155,025.85	3,590,155,025.85
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,418,008.18	1,418,008.18
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	118,544,129.39	118,544,129.39
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,493,897.58	22,493,897.58
1.2.9	Бусад мөнгөн зарлага	27,360,356.42	27,360,356.42
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-145,640,794.34</b>	<b>-145,640,794.34</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	23,761.89	23,761.89
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	23,761.89	23,761.89
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	23,761.89	23,761.89
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	147,150,352.93	147,150,352.93
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	146,583,771.95	146,583,771.95
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	566,580.98	566,580.98
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	306,455,281.51	306,455,281.51
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	292,315,820.88	292,315,820.88
3.2.4	Төлсөн ногдол ашиг	14,000,000.00	14,000,000.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	139,460.63	139,460.63
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-159,304,928.58</b>	<b>-159,304,928.58</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-304,921,961.03</b>	<b>-304,921,961.03</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	335,979,333.87	335,979,333.87
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,002,372.84	31,002,372.84



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

2024.03.06



Ган хийц ХК  
2023 оны санхүүгийн тайлангийн  
бодит байдлын тухай мэдэгдэл

2023 оны 12 - р сарын 31-ны өдөр

Гүйцэтгэх захирал Д.Оюунзул, нягтлан бодогч Х.Ариунсанаа бид манай аж ахуйн нэгжийн 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг " Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 9.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд :


1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Д.Оюунзул

НЯГТЛАН БОДОГЧ

..... Х.Ариунсанаа



## УДИРДЛАГЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЗАХИДАЛ

Манай байгууллагын 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу бэлтгэсэн талаар саналаа илэрхийлэх зорилгоор энэхүү захидлыг бичиж байна. Бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй гэдгээ баталгаажуулж байна.

Энэ захидалд харуулсан зарим зүйлүүд нь материаллаг гэж үзэх боломжгүй байж болох юм. Учир нь бид санхүүгийн тайлангийн хэрэглэгчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц алдаа эсвэл буруу тайлагналыг материаллаг гэж үзсэн.

Бид 2024 оны 03 сарын 04-ний өдрийн байдлаар өөрсдийн мэдлэг, итгэл үнэмшлийн дагуу дараах зүйлүүдийг баталгаажуулж байна.

- Бид санхүүгийн тайлангуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн.
- Бид санхүүгийн холбогдолтой бүх данс бүртгэл, тоо дүн, бүх шатны удирдлагын хурлын тэмдэглэл болон саяхан болсон боловч хараахан бэлтгэгдээгүй байгаа хурлын тэмдэглэл зэрэг бүх мэдээллээр хангасан.
- Санхүүгийн тайлагналтай холбоотой аливаа хууль бус үйл ажиллагаа явуулсан талаар холбогдох байгууллагаас мэдээлэл ирээгүй.
- Бүртгэл тайланд тусгагдаагүй аливаа материаллаг ажил гүйлгээ байхгүй.
- Удирдлага болон бусад гүйцэтгэх ажилтнуудтай холбоотой залилан эсвэл санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх залилантай холбоотой нөхцөл байдал үүсээгүй.
- Холбоотой талуудын ажил гүйлгээ, бүх гол чухал тооцоолол, удирдлагаас тодруулах ёстой материаллаг шинжтэй бүх зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт бүрэн тусгасан.
- Санхүүгийн тайланд тодруулагдах ёстой хууль зөрчсөн үйл ажиллагаа болон шүүхийн томоохон хэмжээний зарга маргаан, ирээдүй үеийн өр төлбөртэй холбоотой асуудал үүсээгүй.
- Байгууллага нь бүх хөрөнгийнхөө хувьд хууль ёсны эзэмшлийн гэрчилгээтэй бөгөөд хөрөнгийг хууль бусаар ашиглах гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зүйл гараагүй.
- Санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөх бүх гэрээ хэлэлцээрүүдийг бид дагаж мөрдсөн.
- Тайлагналын өдрийн дараах аливаа үйл явдал тохиолдоогүй бөгөөд энэхүү захидал бэлтгэсэн өдрийн байдлаар залруулга болон тодруулга шаардлагатай ажил гүйлгээ гараагүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ



/ Д.Оюунзул /  
/ Х.Ариунсанаа /



Д. ОЮУНЗУЛ



Ж.БЯМБАЖАВ

## АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 02-р сарын 14-ний өдөр

№ 24/01

Улаанбаатар хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү АУДИТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хуулийг үндэслэн, нэг талаас Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг 7-р хороо Наран гудамж Ган Хийц ХК-18140, регистр: 2090988, "Ган Хийц" ХК /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Д. Оюунзул нөгөө талаас Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 2 хороо, Оршил 2 төв, "Дундманхайдай аудит" ХХК-ийг төлөөлж /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ Менежер Б.Цэвэлмаа нар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулав.

1.2. Тус гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь ГАН ХИЙЦ ХК-ны 2023 оны санхүүгийн тайлан тэнцэл, аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн биелэлт, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан тайлант үеийн санхүү бүртгэл, мөнгөн хөрөнгө, хөрөнгө материалын хөдлөлийн бүртгэл, боловсруулалт, нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, бүртгэлийн программ хангамжийн хөтлөлт, татвар, даатгалын тайлагнал, үндсэн үйл ажиллагааны биелэлт, гэрээ, худалдан авах ажиллагааны талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд байгууллагын захиалгын дагуу аудитын ажил гүйцэтгэн, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Захиалагч тал нь холбогдох анхан шатны баримт материал, санхүүгийн тайлан мэдээгээр ханган, хөрөнгө бараа материалын эзэмшилт ашиглалтын байдлыг газар дээр нь үзэх бэлтгэл ханган зөвлөгөө авах ба, гэрээний төлбөр гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага болон бусад харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1. Гэрээний үйлчлэх хугацаа: 2024 оны 02 сарын 14-ний өдрөөс ажлын 14 хоногт
- 2.2. Хугацааг тоолоходоо гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хуанлийн тооллыг удирдлага болгоно.

### Гурав. Гэрээний үнэ, ажлын хөлс

- 3.1. Гэрээний нийт ажлын хөлс нь 5,000,000 (Таван сая) төгрөг байна. Энэ үнэд НӨАТ багтсан болно.
- 3.2. Захиалагч нь Гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор урьдчилгаа 60 хувийн төлбөрийг ХААН банкны 5020650867 тоот дансанд, үлдэх төлбөрийг үүргээ биелүүлж Захиалагч талд аудитын дүгнэлт тайлан хүлээлгэн өгсний дараа үлдэх 40 хувийн төлбөрийг ажлын 3 хоногийн дотор Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн төлбөрийг ХААН банкны 5020650867 тоот дансанд тус тус шилжүүлнэ.

### Дөрөв. Ажил хүлээлцэх

- 4.1. Гүйцэтгэгч нь аудитын ажлыг гүйцэтгэж дуусмагц гэрээ дүгнэн хүлээлгэн өгнө.
- 4.2. Захиалагч нь гэрээт ажлыг дүгнэн хүлээн авна. Уг баримт нь гэрээний салшгүй хэсэг болно.

### Тав. Талууд эрх, үүрэг

- 5.1. Захиалагчийн эрх, үүрэг: